

## НЭЭЛТТЭЙ НИЙГМИЙН ТУХАЙ КАРЛ ПОППЕРИЙН СУРГААЛ, ПОЛИТОЛОГИЙН АГУУЛГА

Ц.ГАНБОЛД

*Профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим*

Э.БАТ-ЭРДЭНЭ

*Улс төр судлалын тэнхимийн докторант*

**Түлхүүр үг:** Карл Раймунд Поппер, нээлттэй нийгэм, хаалттай нийгэм, дарангуйлал, ардчилал, Фальсификаци, шүүмжлэлт рационализм, няцаах зарчим, нийгмийн инженерчлэлийн онол, судалгааны арга зүй, улс төрийн шинжлэх ухаан, марксист онол сургаал, түүхчлэх үзэл, улс төрийн сургаал, гүйцэтгэх засаглал, иргэний хяналт

**Хураангуй:** Тус өгүүлэлд Английн философич, улс төр судлал, нийгмийн ухааны эрдэмтэн Карл Раймунд Попперийн намтар, судалгааны арга зүй, ном бүтээлүүд мөн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллүүдийн үзэл санаа, агуулгыг судлан авч үзсэн юм. Өгүүллийн гол агуулга нь Карл Попперийн онолын түвшинд дагнан судалсан “нээлттэй нийгмийн” тухай үзэл сургаал, түүний улс төрийн шинжлэх ухааны агуулгыг судлан, тодруулахад чиглэгдсэн болно.

### 1. Намтар, судалгааны арга зүйн үзэл баримтлал

Нээлттэй нийгмийн тухай үзэл санаа, ойлголт нь ардчилалын үүсэл, хөгжлийн үйл явцаас аваад өнөөг хүртэлх хөгжлийн хамгийн түгээмэл, суурь ойлголт, үнэт зүйл юм. Үүнийг улс төрийн шинжлэх ухаан болон нийгмийн ухааны бусад шинжлэх ухааны эрдэмтэн судлаачид өөрийн судалгаа, онол үзэл баримтлалын гол төвд тавин судалдаг олон баримтуудаас харж болно. Энэхүү өгүүлэлд нээлттэй нийгмийн үзэл санааг дагнан судалж, шинжлэх ухааны эргэлтэнд оруулсан Английн философич, улс төр судлал, нийгмийн ухааны эрдэмтэн, судлаач Карл Раймунд Попперийн намтар, судалгааны арга зүй, эх зохиолууд, түүний улс төр судлалын агуулга, үзэл санааг авч үзсэн юм.

Карл Раймунд Поппер нь 1902 онд Австри улсын Вена хотноо эрдэмтэн гэр бүлд төрсөн байна. Түүний аав нь эрх зүйн ухааны профессор цолтой эрдэмтэн хүн байжээ. Тэрээр Венийн их сургуульд элсэн орж, математик, сэтгэл судлал, физик зэрэг олон төрлийн шинжлэх ухааныг судлан, өөрийн судалгааны анхны гарааг эхлүүлсэн байна. Венийн их сургуульд суралцаж байх хугацаандаа Марксын сургаал, номлолыг шимтэн судалж, өөрийн гэсэн томоохон ойлголт, үзэл хандлагыг төлөвшүүлж чадсан юм. Гэвч хожим марксизмын зорилго нь шударга, гуманист агуулгатай боловч зорилгодоо хүрэхийн тулд тодорхой онол, хөгжлийн загвар байхгүй, зөвхөн инстинктээр явж ирсэн хэмээн буруутгаж, орхисон байна. Карл Поппер 1937 онд Австри улсыг орхин Шинэ Зеланд руу цагаачлан дүрвэж, Кентербергийн их сургуульд багшлах болжээ. Түүний Австри улсаас дүрвэн гарсан шалтгаан нь антинацист үзэлтэй холбоотой юм. Тухайн үед европт нацист үзэл ихээхэн дэлгэрч, энэ үзэл суртал, хандлагыг гол болгосон нам, улс төрийн хүчин төрийн эрхийг авч байсан нь түүнд ихээхэн аюулыг дагуулсан юм. Хожим тэрээр 1946 онд Лондонгийн Эдийн засаг-Улс төрийн сургуулийн урилгаар Англи улсад ирж тус сургуульд багшилж эхлэн, 1949 оноос логик, шинжлэх ухааны арга зүйн онолын профессор болсон билээ. 1969 онд Америкийн Нэгдсэн Улсын Брандын их сургуульд багшлан, 1975 он хүртэл тэтгэвэрт гарах хүртлээ тус сургуульд багшилж, судалгааны ажил хийсэн байна. Карл Поппер 1950 онд Америкийн Нэгдсэн Улсад зочлон, Харвардын их сургуульд лекцээ уншсанаас хойш олон удаа уригдаж, түүний зохиол бүтээл, онол сургаалыг хүндэтгэлтэйгээр хүлээн авах болсон юм.

Карл Раймунд Поппер шинжлэх ухааны судалгааны арга зүй, түүнд тулгуурласан онолын хууль, арга, арга зүйг боловсруулсан нь бие даасан томоохон хандлага, үзэл баримтлалыг бий болгосон юм. Түүний судалсан объектив мэдлэгийн онол, үзэл баримтлал, нийгмийн инженерчлэлийн онол, шүүмжлэлт рационалист арга зүйн үзэл баримтал, фальсификацийн онолын зарчим зэрэг нь шинжлэх ухааны судалгаанд томоохон арга, арга зүйн хандлага болон төлөвшсөн төдийгүй, энэ чиглэлийн онолын судалгаанд томоохон бие даасан онол-хандлага, үзэл баримтлал болон төлөвшжээ. Карл Поппер арга зүй хэмээх ухагдахууныг арга хэмээх ойлголтоос уламжлуулан авч үзсэн юм. Арга бол шинжлэх ухааны дүгнэлтүүдтэй бидний ажиллах хэв

маяг хэмээн авч үзсэн нь омнох үеийн сэтгэгчдээс илүү плюралист утга, агуулгатай болгосон юм<sup>1</sup>. Карл Поппер "Түүхчлэх үзлийн гүйланчлал" бүтээлдээ шинжлэх ухааны аргыг байгальч ба байгальч бус хэмээн хоёр хэсэгт хуваан авч үзэн, байгальч буюу эрэг, байгальч бус буюу эсрэг хэмээн нэрлэн тайлбарлаж үзсэн байна<sup>2</sup>.

Тэрээр өөрийн шинжлэх ухааны арга зүйн үндсийг шүүмжлэлт рационализм хэмээн тодорхойлсон байдал. Учир нь аливаа судалгааг үр дүнд хүрэхэд чиглүүлдэг анхдагч арга бол "алдаж-нох" мөн хэмээн үзсэн юм. Энэхүү үзэл баримтлаас шүүмжлэлт рационализмын тулгуур ойлголт болох "няцаах зарчим" буюу фальсификацийн тухай арга зүйг үндэслэсэн болно. Энэхүү онолын гол агуулгыг авч үзвэл аливаа онол алдаатай тухай, алдааг илрүүлэх үндсэн дээр дахин шинэ түвшинд гаргах тухай сургаал юм. Илүү тэрээр нарийвчлан авч үзвэл аливаа онолын дүгнэлтийг бодит туршилтын баримттай жиших, зөрчилдүүлэх явдал юм. Гол нь тухайн няцаагдах зарчмын өмнө аливаа онол нээлттэй байх явдал чухал юм. Онолын нээлттэй байх шинж гэдэг нь уг онолыг баталгаажуулан үнэмшүүлж байдаг эмпирик баримтууд байх ёстой тухад мөн тухайн онол конвенциональ мэдлэгийн хэлбэрт байх болон тодорхой цаг хугацаанд тухайн баримтууд "далд орших" /судлагдаагүй байх/ нь нээлттэй байх чанарыг илэрхийлдэг хэмээн тайлбарлажээ. Карл Поппер энэ тухай өгүүлэхдээ миний үзлийг дэмжиж байгаа хэн ч гэсэн шинэ нээлт гаргахын төлөө, энэхүү шинэ нээлтийн замаар шинжлэх ухааны шинэ алхам бүтээхийг зорьдог. Үүний хамт фальсификацид оруулж байгаа туршилтуудад гол анхаарал тавих хэрэгтэй. Энэхүү туршилтуудыг шинэ амжилт, туршилтын шинэ ертөнцөд нэвтрэн орох замыг гаргаж өгч байна хэмээн талархан хүлээж авах хэрэгтэй юм. Тэр ч бүү хэзэгээр туршилт нь хамгийн сүүлийн үеийн онолын эсрэг аргумент гаргаж өгч байгааг ч сайшаах ёстой хэмээн хэлжээ. Мэдлэгийн үнэн болон худал болохыг шийдвэрлэдэг, шинжлэх ухаанч чанарыг илрүүлэх гол зарчим бол фальсификацийн зарчим юм хэмээн тэрээр тэмдэглэжээ<sup>3</sup>. Дээр дурдагдсан зүйлс болон Карл Попперийн фальсификацийн тухай сургаалаас дараах дүгнэлтийг хийж болох юм. Фальсификацийн зарчим нь аливаа онолын бүх зүйлийг няцаанаа гэсэн үг биш юм. Зөрчил гарах болон түүнтэй холбогдсон тодорхой асуудал бэрхшээлүүдийг шийдвэрлэх, алдаатай хэсгийг засварлах тухай асуудал юм хэмээн үзэх ёстой. Энэ үүднээс онолын баттай үнэн байх шинж нь улам өснөх хэмээн үзсэн байна. Тэрээр өөрийн шүүмжлэлт рационализмын үзэл санаа, фальсификацийн онолын зарчмыг үнэлэн, дүгнэхдээ "Мэдлэгийн шүүмжлэлт онол нь танимжийн бүх онолын томоохон асуудлуудыг бүх талаар тодотгож байгаа юм. Бидний ингэж их, тэгсэг мөртлөө ингэж бага мэдэж байгаагийн учир юу вэ? бид өөрсдийгөө үл мэдэхийн балчгаас яаж зугуухан гарга вэ? энэ бүхний учир шалтгаан нь бид аливаа ойлголтын талаар таамаг дэвшүүлж, түүнийгээ шүүмжлэл сайжруулах замаар ажиллаж байгаад хариулт оршино" хэмээн шүүмжлэлт рационализм, фальсификацийн онолын зарчмын үр дүн, ач холбогдлыг үнэлжээ<sup>4</sup>. Карл Попперийн энэхүү няцаах зарчим, шүүмжлэлт арга зүй нь мэдлэгийн анхан шат буюу ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ч хэрэгжихээр зорьж эхэлсэн юм. Мэтгэлцээний үндсэн дөрвөн хэлбэрийн нэгэнд Карл Попперийн мэтгэлцээн орж, сурагчдын дунд хэрэгжиж эхэлсэнээр ерөнхий суурь мэдлэгийн хүрээнд энэ чиглэлийн арга зүйг төлөвшүүлэх, аливаа ойлголт мэдлэгийг хүлээж авахдаа хэрэгжүүлэх үндсэн хандлага болгоход томоохон алхам болсон юм.

## 2. Голлох ном, бүтээлүүдийн агуулга, нээлттэй нийгмийн тухай үзэл санаа

Карл Раймунд Попперийн анхны бүтээл нь "Шинжлэх ухааны судалгааны логик" нэртэйгээр 1933 онд хэвлэгдээ. Тэрээр уг зохиолдоо нийгмийн хөгжил, хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлс, түүний хувирал өөрчлөлтүүд дан ганц мэдлэгт суурилах ёстой хэмээн авч үзсэн байна. Харин өнөөг хүргэл хүн төрөлхтөө энэ чиглэлийн төгс онол, судалгааг хийж чадаагүй учир хүн төрөлхтний хөгжлийг угтан өгүүлэх боломжгүй хэмээн үзжээ.

Карл Раймунд Попперийн дараагийн бүтээл нь 1937 онд хэвлэгдэн гарсан "Диалектик гэж юу вэ?" хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэл юм. Энэхүү өгүүлэл нь түүний Кентергбергийн их сургуульд уншсан лекцийн эхтэй юм. Тус өгүүлэл нь хожим Английн философиийн "Mind" сэтгүүлд хэвлэгдэн гарч, эдүгээ түүний томоохон судалгааны тоонд зүй ёсоор ордог бүтээл билээ. Тэрээр энэхүү өгүүлэлдээ ардчилсан бүх нийгмийн үзэл сурталууд, тэдгээрийн үзэл баримтлал, арга зүйн тухай авч үзсэн юм. Мөн марксизмыг улс төрийн сургаалынх нь хувьд догматизм болсон хэмээн баталж, шинжлэх ухааны хөгжилд энэ мэт догматизм маш их хор хөнөөлийг дагуулдаг хэмээн үзжээ. Харин үүний оронд шинжлэх ухааны хөгжлийн гол үндэс нь бодол, сэтгэлгээ, оюун ухааныг уралдуулах явдал юм. Энэхүү үзэл баримтлааас түүний шинжлэх ухааны судалгааны гол зарчим болох шүүмжлэлт рационализм, фальсификацийн онолын зарчмын гол агуулга, үзэл санаа үндэслэн гарсан юм.

<sup>1</sup> Д.Баттөмөр. "Нээлттэй нийгмийн тухай К.Попперийн үзлийн арга зүйн сурвалж ба үндсэн агуулга" өгүүлэл. "Шинэ толь" сэтгүүл. №23. 115-р тал. УБ., 1998 он

<sup>2</sup> Карл Поппер. "Түүхчлэх үзлийн гүйланчлал". 67-69-р тал. УБ., 1995 он

<sup>3</sup> Д.Баттөмөр. "К.Попперийн фальсификацийн зарчим" өгүүлэл. "Шинэ толь" сэтгүүл. №4. 115-р тал. УБ., 1994 он

<sup>4</sup> Карл Раймунд Поппер. "Нээлттэй нийгэм, түүний дайснууд" (II боть). 439-р тал. УБ., 2009 он

Карл Попперийн үзэл санаа, сургаалийн гол хэсгийн нэг нь түүний улс төрийн сургаал, ардчилал, нээлттэй нийгмийн үзэл санаа, түүний хөгжилд тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн даван туулах тухай юм. Мөн тэрээр хүн төрөлхтний нийтлэг түүх оршин байдаггүй, зөвхөн тоо томшгүй олон хүний бүхий л талын түүх оршин байдал. Харин тэдгээрийг нэгтгэж байдал зүйл нь улс төрийн эрх мэдлийн түүх байдаг хэмээн үзжээ. Энэ түүх нь дэлхийн түүх болон хөгжсөн. Хүн төрөлхтний бодит түүх оршин байдаг хэмээн үзэх юм бол бүх хүний түүх гэж байх ёстой. Яагаад гэвэл зарим нэг хүнээс илүү чухал хүн гэдэг ойлголт оршин байдаггүй юм хэмээн тэмдэглэсэн байна.

Карл Раймунд Попперийн нээлттэй нийгмийн тухай үзэл санаа, улс төрийн сургаалын агуулга нь “Нээлттэй нийгэм, түүний дайснууд” бүтээлээс нь эхтэй юм. Тэрээр өөрийн гол, үндсэн эх зохиол хэмээн нэрлэж болох “Нээлттэй нийгэм түүний дайснууд” бүтээлээ 1938-1943 онуудад Шинэ Зеландад байх хугацаандаа бичсэн юм. Энэхүү бүтээлийн эхний хэвлэл нь 1945 онд Англи хэл дээр хэвлэгдсэн байдал. Тэрээр энэхүү зохиолдоо Гераклит, Платон, Гегель, Маркс зэрэг томоохон сэтгэгчидийн үзэл сургаалыг түүхчлэх үзэл нэвт шингэсэн, догматизм болсон үзэл, сургаалууд хэмээн үзжээ. Тэрээр дээрх сэтгэгчдийн үзэл, сургаалыг догматизм болохын хувьд үгүйсгэж, нээлттэй нийгмийн үзэл санаа, ардчилалын үйл хэрэгт ямар хэмжээний хохирол учруулсан аюултай үзэгдэл болохыг өөрийн дэвшүүлсэн аргументууд, үзэл хандлагаар батлахыг зорьсон юм. Энэхүү бүтээлийн агуулга үзэл санаа, бичигдсэн хэлбэрийг авч үзвэл түүхчлэх үзэл ба нийгмийн инженерчлэлийн арга зүйн хооронд дахь шинжлэх ухааны мэтгэлцээн, шүүмж хэмээн үзэж болно. Тэрээр хаалттай нийгмийн үндсэн институц бол тоталитарист шударга ёс, догматизм болсон хорио цээр, түүхчлэх үзэл, оюун санааны үл гүйцэлдэх үзэл, иргэдийг дунд нь хатуу хуваасан анги давхраа .., зэрэгт оршдог. Харин нээлттэй нийгэм нь аливаа шийдвэрийг аль нэг шашин, хорио цээрийн үхширсэн үзэл санаанд бус оюун ухаан, иргэд хоорондын хамтын шийдвэрт тулгуурлаж гаргадаг, хуулийн засаглал, чөлөөт эдийн засаг, монополийг үгүйсгэсэн олон ургальч үзэл санаа, иргэд нь амар тайван, аз жаргалтай амьдардаг, аливаад хариуцлагатай, бүтээлч мөн шүүмжлэлтэй хандаж чаддаг явдал нь гол амин сүнс, үнэт зүйл юм хэмээн үзжээ. Түүний нээлттэй нийгмийн тухай үзэл санааг дүгнэн авч үзвэл нийгмийн хөгжлийг урьдаас харж, түүний зүй тогтол, загварыг нээж, тэрхүү хуулиар хүн төрөлхтөн хөгжинө гэсэн ангич үзлийн үүднээс улс төрийн зорилгоор бус харин шинжлэх ухааны үүднээс алагчлалгүй шүүмжлэн няцааж чаддаг ардчилсан чөлөөт нийгэмд л хүний бүтээлч чанар жинхэнэ утгаараа илэрнэ хэмээн үзсэн юм. Ардчилсан нийгэмд хүн өөрөө өөрийнхөө хувь заяаны эзэн байх боломж байдал нь нийгмийн хөгжилд өмнө байгаагүй томоохон түлхэц, хөдөлгөгч хүч байх болно. Үүний тулд нээлттэй, ардчилсан нийгмийн үзэл онолыг ихээхэн ухаалгаар боловсруулахыг чухалчлан, нээлттэй нийгмийн зарчмыг дараах байдлаар томъёолсон юм. Үүнд:

1. Ардчилсан сонгууль нь нээлттэй нийгмийн гол институцийн нэг боловч түүнийг олонхийн засаг хэмээн үзэж болохгүй. Учир нь олонхи ч дарангуйлалын аргаар удирдаж болно. Энэхүү үзэгдлээс хамгаалах хамгийн найдвартай арга нь эрх баригч нам эвслийн засаг хязгаарлагдсан байх ёстой. Нэг ёсондоо ардчилалын үед ард түмэн цус урсгалгүйгээр засгийн газрыг огцруулж чадах тийм л тогтолцоо хэрэгтэй. Тийм учир засгийн эрхийг баригчид нь тайван өөрчлөлт хийх бололцоо цөөнхөд олгодог нийгмийн байгууллагуудыг хамгаалахгүй бол тэдний засаглал дарангуйлалаас ямар ч ялгарах зүйл үгүй. Тиймээс нээлттэй нийгмийн үзэл санааны тулгуур нь цөөнх болсон иргэдийн суурь эрх болон улс төрийн эрхийг хамгаалсан тухайлсан хуультай байх ёстой хэмээн үзсэн байна.
2. Гүйцэтгэх засаглалын институтыг хоёр л хэсэгт хуваан авч үзнэ. Нэг нь дээрх хүний эрхийг хамгаалсан тогтолцоо бүхий засгийн газар, үлдсэн нь буюу бусад тоталитар шинж бүхий Засгийн газар юм.
3. Жинхэнэ ардчилсан мөн чанарыг өөрт агуулсан Үндсэн хууль нь тухайн нийгмийн зөвхөн нэг үзэгдлийг л хязгаарласан байх ёстой. Тэр нь уг нийгмийн ардчилсан үзэл санаанд аюул учруулах үйлдэл, үзэл санаануудыг хязгаарлах явдал юм.
4. Ардчилсан засаглалын үед мөрдөгдөж байх учиртай цөөнхийн эрхийг хамгаалсан хууль, эрх зүйн тогтолцоо нь нээлттэй нийгэмд өшөрхөгчид, нийгмийн үнэт зүйлд хор учруулсан үйлдэлд үйлчлэхгүй байх ёстой.
5. Ардчилал, нээлттэй нийгмийг хамгаалах байгууллагуудыг төлөвшүүлэх бодлого нь эрх баригчдын ч дотор ардчилалыг эсэргүүцсэн далд хандлага байж болно гэсэн таамагт үндэслэх ёстой.
6. Хэрэв нээлттэй нийгмийн үзэл санаа устаж, ардчилал үгүй болвол нээлттэй улс төрийн бодлого, эрх зүй үгүй болно. Энэ тохиолдолд засгийн эрхийг баригчид эдийн засгийн ямар нэгэн үнэт зүйлийг хадгалж чадаж байвал тэр нь гагцхүү азаар л хадгалагдаж байгаа юм.
7. Аливаа эрх баригч хүчин, Засгийн газруудын эн тэргүүний ажил бол ардчилал, түүний үнэт зүйлсийг ойлгох, түүнийг төлөвшүүлэх, хадгалах нь эн тэргүүний эрх ашиг хэмээн ухаарч сэтгэхээс эхэлнэ хэмээн үзсэн юм. Үгүй бол ардчилал, нээлттэй нийгмийн талаар дутуу ойлголт, тууштай бус занд хөтлөгдсөн нийгмийн бүлэг хэзээд оршин байдаг нь нийгмийн хөгжлийн хууль учир ардчилалд өшөрхсөн үзэл санаа ил, далд хэлбэрээр оршсоор байх болно хэмээн үзжээ.

Нээлтгэй нийгмийн хөгжил, ардчилалын тухай Карл Раймунд Попперийн туурвисан дараагийн үүгээл нь “Марксын зогнол ба Марксын ёс зүй” нэртэйгээр хэвлэгдсэн юм. Энэхүү бүтээлийн гол агуулга нь Марксист философи, үзэл сургаалыг үзэл суртлын агуулга нэвт шингэсэн, шинжлэх ухаанч чанар үгүй хэмээн шүүмжилсэн үзэл санаа, хандлага юм. Учир нь Марксист үзэл сургаал нэг талаас диалектик чанарыг огт тусгаагүй, ногөө талаас шүүмжлэлт үзэл санаа тусах боломжгүй зөвхөн монолог, тулгалт, дарангуйлалыг хүлээн зөвшөөрсөн байдаг нь ардчилсан бус мөн шинжлэх ухаанч чанар үндэслэл огт тусгагдаагүйн тодорхой баримт жишээ юм. Энэ төрлийн нийгэмд амьдарч буй иргэд улс төрийн соёл, оролцооны талаар төсөөлөл байхгүй, зөвхөн улс төрийн үзэгчид л болдог тухай өгүүлсэн байна. Карл Марксын үзэл, сургаал нь нийгмийн хэт ялгавартай байдлыг шүүмжлэн эсэргүүцэж гарч ирсэн ч үнэн хэрэгтээ тийм ч шударга зүйл биш байсныг түүх баталсан хэмээн үзсэн юм. Хамгийн гол нь Марксын үзэл санааны алдаатай тал нь шинжлэх ухаанч, хүмүүнлэг үзэл, сургаал бус хэн нэгэн хүний төрийн эрх мэдэлд хүрэхэд ашиглагддаг, тэрхүү эрх мэдлийг абсолют хэмжээгээр удаан оршин тогтоноход зориулагдсан зэвсэг төдий зүйл юм хэмээн үнэлсэн байна. Тийм учир агуу суут хүмүүсийн зохион бүтээж гаргасан ямар ч гайхамшигтай, хүн төрөлхтний оюуны өвд үлдэх гавьяатай үнэт зүйл байсан ч тэрхүү үзлийг хэт даган дуурайж, гагцхүү энэ л зөв онол сургаал хэмээн үзэхээс ангижрах хэрэгтэй гэдгийг уг бүтээлдээ онцолсон юм. Энэ тухай Амеркийн философич, улс төр судлаач Уолтер Липман өгүүлэхдээ “Гэгээрсэн хүн зоныг ийм эмгэнэлтэйгээр хуваасан өнөөгийн ёртөнц дахины ёс суртахууны хагарал нь чөлөөт шинжлэх ухааны дорийтлоос үүдэлтэй юм” хэмээн хүйтэн дайны үед тэмдэглэсэн нь цаад утга санаа нь марксист онол, сургаалийг шүүмжилж, шууд чиглэсэн үзэл санаа юм.

Карл Попперийн ардчилал, нээлттэй нийгмийн талаар бичсэн томоохон нэг сэдэвт зохиолууд, эрдэм шинжилгээний өгүүлэлүүд нь тухайн үеийн ардчилал, нээлттэй нийгмийн судалгаанд томоохон хувь нэмрийг оруулж, энэхүү үнэт зүйлсийг үнэлэх иргэдийн хандлага, ойлголт болон энэ чиглэлийн онолын судалгааны хөгжлийг шинэ түвшинд гаргасан хэмээн судлаачид үнэлдэг билээ. Түүний энэ чиглэлийн томоохон өгүүлэл, судалгааны бичвэрүүдийн нэг нь 1955 онд хэвлүүлсэн “Олон нийтийн санаа бодол ба либерализмын зарчмууд” өгүүлэл юм. Тус өгүүллийн гол үзэл санаа нь “олон нийтийн санаа” хэмээх ойлголтыг голлон авч үзсэн байна. Учир нь иргэдийн нийтээр гаргасан шийдвэр, ард түмний шийдвэр хэмээх ойлголт нь нээлттэй нийгмийн тулгуур үзэл санаа мэт боловч хариуцлагын тухай ойлголтууд байдаггүй нь томоохон сүл тал юм хэмээн үзсэн байна. Учир нь нээлттэй нийгэмд энэ чиглэлийн иргэдийн нийтийн хүсэл зоригийг хязгаарлах, ард түмний дур зоргод төрийн зүгээс зохицуулах тухай ойлголт байхгүй нь учир дутагдалтай хэмээн үзжээ.

Карл Раймунд Попперийн бичсэн “Ардчилал ба ардчилсан ёс” хэмээх өгүүлэл нь түүний судалгааны харьшангий сүүл үед бичигдсэн бүтээл юм. Тэрээр энэхүү бүтээлдээ өөрийн нээлттэй нийгэм, ардчилалын талаарх судалгааг хураангуйлан дүгнэж авч үзсэн байна. Ихэнх судлаачид засгийн эрхийг хэн барих тухай асуудлыг тодорхой нийгмийн анги, хувь субъекттэй холбоотойгоор судлан үзсэн байдал. Тухайлбал Платон нийгмийн шалгарсан шилдэг сайчууд, Аристотель шалгарсан язгууртан элитүүд удирдах ёстой хэмээн үзсэн бол Маркс ажилчин анги, хамтын ухамсарт нийгэм удирдана гэж үзжээ. Харин Карл Поппер энэхүү ойлголтыг нийгмийн тогтолцооны хүрээнд судлан, тайлбарласан юм. Тэрээр энэхүү өгүүлэлдээ арчаагүй эрх баригчдаас цус урсгалгүй хэрхэн, ямар арга замаар салж болох вэ? хэмээн ерөнхий агуулгаа тодорхойлон, энэ бол ардчилалын онол, түүнийг хэрэгжүүлэх загварууд гэж үзжээ. Гэхдээ энэ бол ард түмний олонхийн засаглал, дарангуйлал огт биш, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн хяналт бодитоор оршиж байх эрх үүрэг, нөхцөл юм. Өөрөөр хэлвэл ардчилал гэдэг нь иргэдийн олонхийн ноёрхол огт биш, гол нь гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн зүгээс тавих хяналтын цогц түүнд тулгуурласан чөлөөт институтууд, чөлөөт сонгууль, нээлттэй нийгмийн үзэл санааг илэрхийлсэн эрх зүйн систем зэрэг нь ардчилалын тулгуур зарчим, үнэт зүйл юм хэмээн үнэлжээ.

### 3. Дүгнэлт

Карл Раймунд Попперийн дээрх ном бүтээлүүд, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа нь орчин цагын ардчилал, нээлттэй нийгмийн тухай үзэл санааг шинжлэх ухааны ахьсан түвшинд гаргахад тодорхой ач холбогдол үзүүлсэн билээ. Учир нь эдүгээ иргэншсэн, соёлт хүн төрөлхтний нийгэмд аливаа нэгэн улс төрийн сургаал, хэт нэг талыг тахин шүтсэн номлолыг дагах нь хүн төрөлхтний хамгийн том аюул юм гэдгийг дэвшүүлэн тавьж, батлахыг зорьсон юм. Энэхүү аюулыг баталсан хамгийн тод жишээ нь хүйтэн дайны үеийн үзэл суртлын хуваагдал байсныг дурдан, марксист сургаал номлолыг сохроор тулган шаардаж, ард түмний итгэл үнэмшил болгосон нь дэлхий дахиныг ямар аюултай зам руу хөтөлсөн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй нотолсон явдал юм. Тийм учир аливаа үзэл сургаалын зорилго нь хүмүүнлэг, гэгээлэг байсан ч түүнийг шүүмжлэлт үзэл санаа хэрэгжиж, өрнүүлэх боломжгүй, фальсификацийн зарчим хэрэгжихгүй монолог шинжтэй байх аваас дарангуйлалын үндэс, суурь бэлтгэгдэх урьдаач нөхцөл хэмээн үзжээ.

Карл Раймунд Попперийн нийгэм, улс төр судлалын судалгаанаас судлан үзэхэд хүн төрөлхтний нийгэм нээлттэй нийгмийн үзэл санаанд суурилах үндэслэлийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Энэ нь

<sup>5</sup> Уг ном нь Монгол хэлиээ 2000 онд орчуулагдсан болио. Номыг Түүхийн ухааны доктор, Ю.Болдбаатар орчуулсан байна.

нээлттэй нийгмийн үед хүн бүр сэтгэн бodoх, өөрийн үүрэг хариуцлагыг ухамсарлах, нийгмийн тодорхой институт бүрт шинэчлэл хийх, плюрализм нээлттэй орших эрх, баталгаа дан ганц энэ нийгмийн үед л оршдог. Хичнээн ардчилсан, олонхийн засаглалын онол, сургаал байсан ч тэрхүү сургаалийг төрийн засаглалын дарангуйлал, тулгалтаар явуулах нь дарангуйлалын хэлбэрт л шилжиж байгаа тухай тэрээр өгүүлсэн юм. Тиймээс хамгийн эхэнд нээлттэй нийгмийн тухай үзэл санаа, онол байх ёстой хэмээн авч үзсэн байна. Нэг ёсондоо Карл Попперийн улс төрийн онол нь нээлттэй нийгэм, ардчилсан засаглал, хүмүүнлэг нийгэм гэсэн гурвалсан холбоонд оршино хэмээн үзэж болох юм. Гэхдээ бүхий л хүмүүнлэг, ардчилалын үнэт зүйлс төрийн бодлого гагцхүү нээлттэй нийгмийн үзэл санаанд суурьлах тухай, тиймээс нээлттэй нийгмийг хамгийн суурь асуудал болохыг анхааруулсан юм. Тэрээр энэ тухай үзэл баримтлалаа шинжлэх ухааны судалгаанд үндэслэсэн өөрийн бүтээлүүдэд буулгасан нь улс төрийн шинжлэх ухаан болон нийгмийн ухааны бусад салбар ухааны судалгаа, мөн хувь хүний ардчилал, түүний үнэт зүйлсийн талаарх ойлголт хандлага шинэ түвшинд төлөвшихөд тодорхой хувь нэмрийг оруулсан болно. Тэрээр “Дэлхий ертөнцөд хамгийн сайхан диваажин байгуулах тухай үзэл санаа ч хүн төрөлхтний ахан дүүс нартаа зориулан байгуулах там болон хувирч болно. Тиймээс шүүмжлэлт үзэл санаа, оюун санааны плюрализм оршин тогтоно цор ганц нөхцөл болох нээлттэй нийгмийн үед л хүн төрөлхтний аюулгүй байдал бүрэн хангагдана” хэмээн үзэж нээлттэй нийгмийн тухай онол, үзэл санаагаа дүгнэсэн юм.

**Abstract:** This article studies about personal autobiography, research methodology, books and creatures, contents and ideas of scientific and research articles of UK philosopher, political researcher and social scientist Karl Raymond Popper, and analyze the creatures and critique by him.

The main contents of the article is to research contents and ideas of major creatures and book of Karl Raymond Popper and to conduct a detailed survey on the teachings on “open society” researched at theoretical level.

## НОМ ЗҮЙ:

1. Карл Раймунд Поппер. “Нээлттэй нийгэм, түүний дайснууд” (I, II боть). УБ., 2006 он
2. Карл Раймунд Поппер. “Түүхчлэх үзлийн гүйланчлал”. УБ., 1995 он
3. Карл Раймунд Поппер. “Марксын зөгнөл ба Марксын ёс зүй”. УБ., 2000 он
4. Д.Баттөмөр. “Нээлттэй нийгмийн тухай К.Попперийн үзлийн арга зүйн сурвалж ба үндсэн агуулга” өгүүлэл. “Шинэ толь” сэтгүүл. №23.. УБ., 1998 он
5. Д.Баттөмөр. “Объектив мэдлэгийн тухай К.Попперийн үзэл баримтлат”. “Шинэ толь” сэтгүүл. № 3. УБ., 1994 он
6. Д.Баттөмөр. “К.Попперийн фальсификацийн зарчим” өгүүлэл. “Шинэ толь” сэтгүүл. № 4. УБ., 1994 он
7. Ш.Ганхуяг. “Түүхийн философи”. УБ., 2006 он
8. Сато Ёожи, Такахиро Хата, Масаюки Нихей. “Суутнуудын санаа бодол хил хязгааргүй”. УБ., 2004 он
9. Г.Батжаргал. “Нийгэм, улс төрийн сэтгэлгээний онолын асуудлууд”. УБ., 2007 он
10. Г.Аюурзана. “Орчин цагын аугаа их сэтгэгчид”. УБ., 2010